



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/199.

Мандалговь

Дундговь аймгийн
“Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 15 дугаар тогтоолоор батлагдсан “Дундговь аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөө”, аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, хөтөлбөрийн хэрэгжилт болон жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлж байхыг хэлтэс, агентлагийн дарга, сум, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (М.Цогзолмаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210526